



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/05/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
Алтай хот	Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
2022 он	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд
	Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
	Аудитор: С.Санчирмаа
	Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ ...	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/	6
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	11
3.5.1 Орлогын данс	12
3.5.2 Зардлын данс	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 183

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Р.ТҮВШИНБАЯР

07020502

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	719,997.2	885,691.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	192,324.6	338,412.6
33	АВЛАГА	208,183.8	111,392.1
35	БАРАА МАТЕРИАЛ	312,767.8	429,165.7
36	НӨӨЦИЙН БАРАА	6,721.0	6,721.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,431,884.4	6,234,404.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,431,884.4	6,234,404.1
39200	Биет хөрөнгө	6,136,257.8	5,940,894.4
39300	Биет бус хөрөнгө	295,626.5	293,509.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,151,881.6	7,120,095.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	126,405.6	127,940.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	126,405.6	127,940.6
41200	Богино хугацаат зээлийн өглөг	18,079.2	16,748.8
41300	Өглөг	108,326.4	111,191.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,025,476.0	6,992,154.8
51	Засгийн газрын хувь оролцоо	7,025,476.0	6,992,154.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,299,870.0	2,299,870.0
51200	Хуримтлагдсан үр дүн	3,501,463.1	3,469,383.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,224,142.8	1,222,901.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,151,881.6	7,120,095.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,112,658.9	3,584,768.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	71,124.6	70,271.2
110	Орлогын албан татвар	64,835.7	62,791.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	64,835.7	62,791.8
113	Хөрөнгийн албан татвар	3,232.0	3,807.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,056.8	3,672.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	360,264.2	558,788.7
120	Нийтлэг татварын бус орлого	360,264.2	558,788.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,681,270.1	2,955,708.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,050,566.3	3,492,806.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,050,566.3	3,492,806.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,265,270.7	2,677,013.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,324,486.1	1,379,253.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,410.3	175,773.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	277,063.9	293,896.2
2104	Хангамж, бараа материалын зардал	62,035.9	73,028.3
2105	Нормативт зардал	59,863.0	201,784.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	218.0	9,447.0
2107	Томилолт, зочны зардал	2,649.6	3,645.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,019.8	48,278.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	328,524.0	491,908.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	785,295.6	815,792.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	62,092.5	91,962.4

Аудитын код: ГАА-2022/05/-НА-СТА-ТТЗ

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	28,214.1	125,283.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	33,878.4	-33,321.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,109,973.0	3,486,547.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	71,124.6	70,271.2
110	Орлогын албан татвар	64,835.7	62,791.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	64,835.7	62,791.8
113	Хөрөнгийн албан татвар	3,232.0	3,807.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,056.8	3,672.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,330.8	2,679.5
1181	Газрын төлбөр	726.0	992.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	303,252.5	456,502.6
120	Нийтлэг татварын бус орлого	303,252.5	456,502.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,735,595.9	2,959,773.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,960,721.3	3,174,890.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,960,721.3	3,174,890.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,121,099.8	2,351,037.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,419,525.7	1,480,721.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,247.4	191,377.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	285,856.8	324,972.7
2104	Хангамж, бараа материалын зардал	151,132.2	148,822.6
2105	Нормативт зардал	45,587.3	90,130.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	864.0	11,868.0
2107	Томилолт, зочны зардал	1,861.6	4,433.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,380.0	50,848.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,644.9	47,861.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	839,621.4	823,853.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	149,251.7	311,657.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	145,869.2	231,836.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	145,869.2	231,836.0
2200	Дотоод эх үүсвэрээр	145,869.2	231,836.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-145,869.2	-231,836.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	76,050.0	66,267.0
14	Бусад эх үүсвэр	76,050.0	66,267.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	79,432.6	146,088.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	112,892.1	192,324.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	192,324.6	338,412.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,990,496.7	0.0	6,990,496.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,100.8	0.0	1,100.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,991,597.5	0.0	6,991,597.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	33,878.4	0.0	33,878.4
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,025,476.0	0.0	7,025,476.0
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,025,476.0	0.0	7,025,476.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,241.4	0.0	1,241.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,026,717.3	0.0	7,026,717.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,241.4	0.0	-1,241.4
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	-33,321.1	0.0	-33,321.1
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,992,154.8	0.0	6,992,154.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төсвийн хэмнэлт, хэтрэлт
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,292,372.30	2,126,597.00	165,775.30
УРСГАЛ ЗАРДАЛ	2,098,873.50	2,045,330.25	53,543.25
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,075,123.80	2,022,687.30	52,436.50
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,372,124.00	1,356,623.27	15,500.73
Үндсэн цалин	1,175,135.40	1,163,893.41	11,241.99
Нэмэгдэл	64,472.90	62,572.49	1,900.41
Унаа хоолны хөнгөлөлт	5,600.00	5,464.72	135.28
Урамшуулал	110,192.10	108,421.66	1,770.44
Гэрээт ажлын хөлс	16,723.60	16,270.99	452.61
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,379.20	175,149.97	4,229.23
Тэтгэврийн даатгал	127,414.40	124,588.49	2,825.91
Тэтгэмжийн даатгал	13,246.80	12,567.32	679.48
ҮОМШӨ-ний даатгал	10,617.70	10,512.91	104.79
Ажилгүйдлийн даатгал	2,647.20	2,556.08	91.12

Аудитын код: ГАА-2022/05/-НА-СТА-ТТЗ

Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эрүүл мэндийн даатгал	25,453.10	24,925.17	527.93
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	310,314.00	308,853.41	1,460.59
Гэрэл, цахилгаан	9,775.10	8,422.97	1,352.13
Түлш, халаалт	295,888.90	295,780.44	108.46
Цэвэр, бохир ус	4,650.00	4,650.00	-
Хангамж, бараа материалын зардал	65,300.20	61,235.79	4,064.41
Бичиг хэрэг	7,118.20	7,098.98	19.22
Тээвэр, шатахуун	45,232.00	42,735.70	2,496.30
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,115.80	3,249.17	866.63
Ном, хэвлэл	1,448.70	1,364.41	84.29
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,940.00	1,491.90	448.10
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,445.50	5,295.63	149.87
Нормативт зардал	64,654.30	54,734.69	9,919.62
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,460.70	23,821.20	2,639.50
Хоол, хүнс	35,193.60	30,006.26	5,187.34
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000.00	907.22	2,092.78
Эд хогшил, урсгал засварын зардал	29,645.70	28,864.80	780.90
Багаж, техник, хэрэгсэл	21,087.90	20,877.80	210.10
Тавилга	2,000.00	1,500.00	500.00
Урсгал засвар	6,557.80	6,487.00	70.80
Томилолт, зочны зардал	8,795.00	3,244.00	5,551.00
Дотоод албан томилолт	8,795.00	3,244.00	5,551.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,892.00	4,299.26	6,592.74
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,755.00	674.00	5,081.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,476.00	648.00	828.00
Даатгалын үйлчилгээ	360.00	294.45	65.55
Тээврийн хэрэгслийн татвар	432.00	131.69	300.31
Тээврийн хэрэгслийн оношлогоо	150.00	88.00	62.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	620.00	440.00	180.00
Газрын төлбөр	399.00	381.00	18.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500.00	489.06	10.94
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,200.00	1,153.06	46.94
Бараа үйлчилгээний бусад зардал	34,019.40	29,682.11	4,337.29
Бараа үйлчилгээний бусад зардал	28,802.60	26,258.19	2,544.41
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,216.80	3,423.92	1,792.88
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,749.70	22,642.95	1,106.75
Бусад урсгал шилжүүлэг	23,749.70	22,642.95	1,106.75
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,599.70	14,084.16	515.54
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,150.00	8,558.79	591.21

Аудитын код: ГАА-2022/05/-НА-СТА-ТТЗ

ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89,905.70	81,266.75	8,638.95
Бусад хөрөнгө	89,905.70	81,266.75	8,638.95
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	103,593.10	-	103,593.10
Эргэж төлөгдөх зээл	103,593.10	-	103,593.10
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,292,372.30	2,263,375.84	28,996.46
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,344,005.00	1,330,806.43	13,198.57
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,344,005.00	1,330,806.43	13,198.57
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	793,972.00	793,570.35	401.65
Орон нутгийн төсвөөс	727,829.30	727,427.65	401.65
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	66,142.70	66,142.70	-
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,540.20	4,152.60	14,387.60
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	18,540.20	4,152.60	14,387.60
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	135,855.10	134,846.45	1,008.65
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,979.70	84,124.05	(76,144.35)
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	112,112.40	50,722.40	61,390.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	91,604.85	(91,604.85)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	228,383.69	(228,383.69)

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Мөнгөн дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	126,020.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	126,020.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	101,777.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,080.76
210101	Үндсэн цалин	17,389.54
210104	Урамшуулал	6,419.02
210105	Гэрээт ажлын хөлс	1,272.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,860.46
210201	Тэтгэврийн даатгал	2,860.46
2104	Хангамж, бараа материалын зардал	3,142.83
210401	Бичиг хэрэг	944.83
210402	Тээвэр, шатахуун	2,187.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10.80
2105	Нормативт зардал	35,396.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,786.77
210502	Хоол, хүнс	2,978.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	631.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,189.06

210702	Дотоод албан томилолт	1,189.06
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,615.45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,615.45
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,093.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,139.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,954.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,242.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	842.92
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	842.92
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	152,084.06
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	152,084.06
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,540.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,887.01
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,407.05
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	23,800.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	26,063.24
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,063.24

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дарив сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн

Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагч 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/21 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн Засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангахад оршино” гэсэн эрхэм зорилго тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,433.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 48.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 38.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 3,492.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 69.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 55.9 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.5 хувиар буюу 32.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 192.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 338.4 сая төгрөг болж, 146.1 сая төгрөгөөр өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгө нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байгаа бөгөөд үүний 22 хувь болох 75.6 сая төгрөг нь сумын ерөнхий орлогын, 0.2 хувь болох 1.0 сая төгрөг нь байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн сангийн, 42 хувь болох 144.0 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн, 23 хувь болох 79.1 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 9 хувь болох 31.3 сая төгрөг нь эрүүл мэндийн төвийн дансанд байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 208.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 110.6 сая төгрөг болж, 97.6 сая төгрөгөөр буурсан. Авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 82.5 сая төгрөгийн, ОНХС-ийн 10.3 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэхтэй холбоотой ЗДТГ-ын 3.2 сая төгрөгийн, байгууллагаас авах авлага 6.3 сая төгрөгийн дарив дулааны авлага барагдсантай холбоотой буурсан байна. Байгууллагаас авах авлага нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн эргэлтийн хөрөнгийн түргэн хөрвөх чадварыг бууруулж цаашид төлөгдөхгүй тохиолдолд үргүй зардал бий болох сөрөг үр дагавартай.

Бараа материалын эхний үлдэгдэл 312.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 429.2 сая төгрөг болж, 116.4 сая төгрөгөөр өссөн, эм боох материал эхний үлдэгдэл 2.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 28.3 сая төгрөг болж, 25.9 сая төгрөгөөр өссөн, хангамжийн материал 16.1 сая төгрөгөөр өссөн, борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө 53.2 сая төгрөг болж тайлант хугацаанд нэмэгдсэн байна.

Бараа материал тайлант оны эцэст 429.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд бараа материал 65 хувь буюу 329.4 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан бэлтгэсэн бол 28 хувь буюу 143.6 сая төгрөгийн бараа материалыг хандиваар, 7 хувь буюу 34.2 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан бол 390.8 сая төгрөгийн бараа материал хасагдаж оны эцэст 429.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,431.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,234.4 сая төгрөг болж, 197.5 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 35.0 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 180.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хандиваар, 76.2 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авснаар нийт 291.9 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, 413.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж, нийт 413.5 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөд 445.4 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан ба шилжүүлсэн болон акталсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл болох 369.5 сая төгрөгийг дансны хасалт хэсэгт тайлагнасан байна.

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 126.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 127.9 сая төгрөг болж, 1.5 сая төгрөгөөр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 21.3 сая төгрөгийн орон нутгийн ерөнхий орлого хөрөнгийн өглөг, 0.6 сая төгрөгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх сангийн өглөг, 105.9 сая төгрөгийн дарив дулааны өглөг, 0.1 сая төгрөгийн засаг даргын тамгын газрын ажилчидтай холбогдох өглөгийн бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,025.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,991.4 сая төгрөг болж, 34.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 15 хувиар буюу 455.5 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 1.2 сая төгрөгөөр хаасан бичилт хийсэн ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 3,468.6 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 70.3 сая төгрөгийн татварын орлого, 558.8 сая төгрөгийн татварын бус орлого, 2,939.1 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 3,568.2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 3,492.8 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 125.3 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Дарив сумын ИТХ-ын 2021 оны 12 дүгээр сарын “Сумын 2021 оны төсөвт тодотгол хийж нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 11 дүгээр тогтоолд зааснаар Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 60.3 сая төгрөгийн татварын, 4.5 сая төгрөгийн татварын бус нийт 64.8 төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 74.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 115 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 1.0 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлогыг 0.1 сая төгрөгөөр, торгуулийн орлогыг 0.3 сая төгрөгөөр тасарсан байна. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

Аудитын код: ГАА-2022/05/-НА-СТА-ТТЗ

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг харьяа байгууллагуудын хувьд тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,292.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,126.6 сая төгрөгийг урсгал зардалд, 81.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,330.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 793.9 сая төгрөгийн, нийгмийн даатгалын сангийн төсвөөс 4.1 сая төгрөгийн, төсөвт байгууллагын өөрийн орлого 134.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,126.6 сая төгрөгийг зарцуулж 16.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 13.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,126.6 сая төгрөг буюу 93 хувьтай байгаа нь 165.8 сая төгрөгөөр, цалин хөлс 15.5 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн 4.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1.5 сая төгрөгөөр, хангамжийн бараа материал 4.1 сая төгрөгөөр, норматив зардал 9.9 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардалд 0.8 сая төгрөгөөр, томилолт, зочны 5.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх 6.6 сая төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 4.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 152.1 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан 1.5 сая төгрөг, засаг даргын нөөц хөрөнгөөс 124.9 сая төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас 1.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 23.8 сая төгрөгийн орлогыг тайлагнасан. 0.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан оны эцэст татан төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн орлогыг цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж бараа материал, нормативд, эд хогшил, урсгал засвар, томилолт, бусдаар гүйцэтгүүлэх, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дарив сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны цахим хуудсанд түүвэрлэн үзэхэд оруулбал зохих 26 мэдээллээс 23 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба 3 санхүүгийн дүгнэлт, тайланг хоцроон мэдээлсэн.

Дарив сумын ИТХ нь тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс 1 төрлийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 66.9 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.

Дарив сумын Соёлын төв нь тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс 1 төрлийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31.7 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг, 99.3 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 21.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 63.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангаар өгөгдсөн шийдвэрээс 58.7 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулаагүй байна.

Харьяа нэгж байгууллагын тухайд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчдад нэгтгэгдэг нэгж байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитын тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар: Засаг даргын тамгын газар 4.5 сая төгрөгийн төлбөрийн акт, Орон нутгийн хөгжлийн сангаар 3.4 сая төгрөгийн төлбөрийн акт, Сум

Аудитын код: ГАА-2022/05/-НА-СТА-ТТЗ

хөгжүүлэх сангийн 11.7 сая төгрөгийн төлбөрийн акт, Дарив дулаан ОНӨААТҮГ-ын 23.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 317.8 сая төгрөгийн албан шаардлага биелээгүй үлдэгдэлтэй байна.

Хэрэгжээгүй шийдвэрийн тухайд байгууллагын удирдлагад биелэлт ирүүлэх албан бичиг хүргүүлсэн төдийгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна. Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авлага, өглөгийн барагдуулалт, аудитын шийдвэрийг хэрэгжилт, орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгайн сан, 1 аж ахуй нэгжийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 сан, 1 аж ахуй нэгжид дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 2, “Хязгаарлалттай” 3, “Сөрөг” 1 дүгнэлт өгсөн байна.

Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 910.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 228.7 сая төгрөгийн алдааг залруулж, 19.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 662.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Аудитаар өгөгдсөн шийдвэрийг чанартай биелүүлж, нотлох баримтаар дэмжигдсэн хэрэгжилтийг өгөгдсөн хугацаанд ирүүлэхийг анхаарах хэрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 7.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайлан болон түүвэрт хамрагдсан байгууллагад залруулга хийгдээгүй.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Санхүүгийн нэгтгэсэн тайлан болон түүвэрт хамрагдсан байгууллагад төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд хог хаягдлын хураамж 1.0 сая төгрөгөөр, газрын төлбөр 0.1 сая төгрөгөөр, торгуулийн орлого 0.3 сая төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалт “Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ

Аудитын код: ГАА-2022/05/-НА-СТА-ТТЗ

хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, Төсвийн тухай хуулийн 14.3 “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” тухай шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Төсвийн тухай хуулийн 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:

Дарив сумын ИТХ

Санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт 3.9 сая төгрөгийн зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд И-баримтгүй 0.7 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын1.1 дэх заалт " Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Дарив сумын Соёлын төв

Санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт 0.8 сая төгрөгийн зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр
Аудитын код: ГАА-2022/05/-НА-СТА-ТТЗ

төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Тайлант онд И-баримтгүй 0.2 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт " Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Санхүүгийн нэгтгэсэн тайланд:

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд түүвэрлэн үзсэн 26 мэдээлэл мэдээлэхээс 3 мэдээлэл хоцроон мэдээлсэн.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг мөрдөн мэдээллээ бүрэн оруулж ажиллах

Аудитын код: ГАА-2022/05/-НА-СТА-ТТ3

Түүвэрт хамрагдсан байгууллага

Дарив сумын ИТХ

2. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд түүвэрлэн үзэхэд 19 мэдээлэл мэдээлэхээс 13 мэдээлэл хоцроож мэдээлсэн.

2.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг мөрдөн мэдээллээ бүрэн оруулж ажиллах

Дарив сумын Соёлын төв

3. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд түүвэрлэн үзэхэд 21 мэдээлэл мэдээлэхээс 15 мэдээлэл хоцроож мэдээлсэн.

3.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг мөрдөн мэдээллээ бүрэн оруулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
Дарив сумын Төвлөрүүлэн захирагч	1	1.3					1	1.3			
Түүвэрт хамрагдсан байгууллага											
Соёлын төв	2	0.8					2	0.8			
ИТХ	2	4.0					2	4.0			
Дүн	5	6.1					5	6.1			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1								1		
Дүн	1								1		
Соёлын төв	2	0.2					1	0.2	1		
ИТХ	2	0.7					1	0.7	1		
Дүн	4	0.9					2	0.9	2		
Нийт дүн	10	7.0					7	7.0	3		